

Цэрэнхандын Буянхишиг^{1✉}

¹Шинжлэх ухааны Академийн Археологийн хүрээлэн,
Монгол улс, Улаанбаатар-13330, Энхтайвны өргөн чөлөө,
Шинжлэх Ухааны Академийн хүрээлэнгүүдийн нэгдсэн 1 байр

Цахиурт овооны ясан сийлбэрт хоромсого

Хураангуй. Сүхбаатар аймгийн Уулбаян сумын нутаг Цахиурт овооны 5-р булшнаас хээ чимэглэл сийлсэн ясан бүрээстэй үйсэн хоромсого гарсан юм. Ясан чимэглэлийг урлахдаа төрөл бүрийн хээ, амьтны дүрсийг маш гоёмсгоор сийлсэн байна. Эдгээрийг ангилан үзвэл геометрийн дүрст хээ, байгаль, ургамлын дүрст хээг сийлээд дунд амьтны дүрсийг сийлсэн үндсэн 3 төрөл байна. Хээ дүрсэлбэрүүд нь өөр өөрсдийн гэсэн утга бэлгэдлийг агуулсан эдийн болон оюуны соёлын төлөөлөл юм. Үүнтэй ижил төрлийн ясан чимэглэл бүхий үйсэн хоромсого Евроазийн төв нутгаар өргөн тархсан ба энэ нь XIII-XVI зууны үеийн монголчуудын оршуулгын дурсгалаас илэрдэг. Энэ төрлийн хоромсого бол хүн болгонд байхгүй тансаг зэрэглэлийн эдлэл бөгөөд зөвхөн чинээлэг язгууртанууд болон гавьяа байгуулсан баатарлаг эрсэд, эсвэл мэргэн харваачдад шагнал болгон өгдөг байсан бололтой. Одоогоор бидний нэгтгэн авч үзсэн нийт 115 хоромсогойн сийлбэртэй ясан чимэглэлүүдийн хээ дүрслэл нь ерөнхий хэв загвар, дүрсэлбэрийн агуулга, арга технологи адилхан боловч хээ чимэглэлийн зохион байгуулалт амьтадын дүрсэлбэр, тэдний үйл хөдлөл нь хоорондоо давхцал үгүй бүгд өөр өөр болох нь харагддаг. Харин Цахиурт овооноос илэрсэн ясан чимэглэл бүхий үйсэн хоромсого бол алтан ургийн язгууртны хэмээн үзэж байна.

Түлхүүр үг: Цахиурт овоо, хоромсого, сийлбэртэй ясан чимэглэл, хээ дүрслэл

Buyankhishig Tserenkhand^{1✉}

¹Institute of Archaeology,
Mongolian Academy of Sciences Building-1,
Peace avenue, Ulaanbaatar 13330, Mongolia

A Bone-Decorated Quiver from Tsakhiurt Ovoo

Abstract. A birch-bark quiver with engraved bone decorations was unearthed from Grave No. 5 at the Tsakhiurt Ovoo site, located in Uulbayan Soum, Sukhbaatar Province, Mongolia. The bone decorations exhibit sophisticated craftsmanship, characterized by a diverse array of engraved ornamental and zoomorphic motifs. These decorations are classified into three primary typological categories: geometric patterns, natural and floral motifs, and compositions centered on animal figures. These iconographic elements represent significant manifestations of both material and spiritual culture, each carrying distinct symbolic meanings. Birch-bark quivers with analogous bone decorations are widely distributed across Central Eurasia and are frequently identified in Mongolian funerary complexes dating from the 13th to the 16th centuries. Quivers of this type are considered prestige goods, likely reserved for the nobility or awarded as meritocratic honors to distinguished warriors and elite archers, rather than being items of common use. While the engraved bone decorations of the 115 quivers analyzed in this study exhibit consistency in overall stylistic form, iconographic content, and manufacturing technique, a detailed examination reveals that the compositional arrangement, animal depictions, and their dynamic postures are entirely unique, with no observable overlap between individual artifacts. Furthermore, the birch-bark quiver with engraved bone decorations discovered at Tsakhiurt Ovoo is attributed to the Chinggisid Golden Lineage (Altan Urug) nobility.

Keywords: Tsakhiurt Ovoo, Quiver, Engraved bone decorations, Iconographic motifs, Chinggisid nobility

Удиртгал

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын төвөөс зүүн хойш 60 км орчим зайд эргэн тойрон ус тойром ихтэй хөндийд орших нэгэн онцгой уулыг Цахиурт овоо хэмээн нэрлэдэг. Энэхүү уулын энгэрээр орших дундад зууны үед холбогдох 40 гаруй булшийг малтан судалсан бөгөөд энэ удаад бид зөвхөн 5-р булшнаас илэрсэн үйсэн хоромсогын ясан чимэглэлийн талаар авч үзэх юм.

Үүнтэй ижил төрлийн ясан чимэглэл бүхий үйсэн хоромсог XIII-XVI зууны үед монголчуудын байлдан дагуулж, оршин тогтнож байсан Евроазийн төв нутгаар өргөн тархсан байна.

Нүүдэлчдийн ахуй соёл бол уламжлалт нүүдлийн мал аж ахуйд суурилсан тэдний өдөр тутмын амьдралын хэв маягтай салшгүй холбоотой. Иймээс малын түүхий эдийг боловсруулж амьдрал ахуйгаа залган аж төрсөөр өдгөө уламжлан иржээ. Мал амьтны ясаар ойр зуурын хэрэглээний эд зүйлсээ хийх болсон нь шинэ чулуун зэвсгийн үеэс эхлэх бөгөөд Хүрэл болон Хүннүгийн үед улам олон төрөл болжээ. Энэ мэтчилэн ясан эдлэлийн гар урлал үе улиран залгамжилж боловсруулалтын арга технологи нь улам хөгжиж ирсэн нь хоромсогын ясан чимэглэл дээр харагдаж байна. Энэ нь XIII-XIV зууны үеийн монголчуудын байлдан дагуулал, хүчирхэгжилт, худалдаа наймаа, татвар, гар урлал зэрэгтэй салшгүй холбоотой бололтой.

Судлагдсан байдал: Монгол улсын нутгаас илэрч олдсон хоромсогын ясан чимэг.

1976 онд Увс аймгийн Зүүн говь сумын нутаг Буурал тохой бригадын нутаг Саран толгойн өвөрт малтсан булшнаас хоромсогын хээтэй ясан чимэглэл олдсон байна (Наваан, 2018: 108, Лхагвасүрэн, 2007: 107).

2007 онд Сүхбаатар аймгийн Онгон сумын нутаг Таван толгойн 11-р булшнаас геометрийн дүрс бүхий хээтэй ясан чимэглэлээр бүрэн хучсан үйсэн хоромсог гарчээ (Өлзийбаяр нар, 2007: 67).

2010 онд мөн Таван толгойн Баруун овоотод малтсан 59-р булшнаас үйсэн хоромсогын ясан чимэглэлийн жижиг хугархай хэсгүүд илэрсэн байна (Төрбат нар, 2010: 34).

2010-2011 онд Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших “Энержи Ресурс” ХХК-ийн “Ухаа худаг” нүүрсний уурхайд авран хамгаалах малтлага судалгаа хийжээ. Энд малтсан 9 дугаартай булшнаас ясан чимэгтэй хоромсог илэрсэн байна (Амартүвшин нар, 2012: 298-324).

2012 онд Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Чандмань Хар ууланд хийсэн авран хамгаалах малтлага судалгаагаар 77 дугаартай булшнаас

хоромсогын амсрын ирмэгийг эмжсэн ясан чимэглэл дээр хар өнгөөр зурсан хээ чимэглэл олджээ. Мөн 216-р булшнаас хоромсогын ясан чимэглэлийн хугархай илэрсэн байна (Амартүвшин нар, 2015: 223, 252).

2013 онд Дорноговь аймгийн Айраг сумын нутаг Баруун Цагаан Дэл уулын “21-р булшнаас хоромсогын ясан чимэглэл илэрчээ. (Батсайхан нар, 2015: 325) 2013 онд Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших Таван толгойн нүүрсний уурхайн талбайд малтсан ЕТТ 6 болон ЕТТ 10 дугаартай булшнаас хоромсогын хээтэй ясан чимэглэл илэрсэн байна (Эрэгзэн нар, 2013: 33, 55).

2016 онд Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт “Жавхлант Орд” ХХК-ийн шинээр тавих авто замын шугамын дагууд археологийн авран хамгаалах хайгуул судалгааны ажлыг хийж гүйцэтгэжээ. Энд 6 дугаарын булшнаас үйсэн хоромсогын урт нарийхан хэлбэртэй ясан даруулга илэрсэн байна (Амартүвшин нар, 2016: 60).

2020 онд Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Хэрлэнбаян-Улаан тосгоны төвөөс баруун хойш орших Ханзат уулын 4 дугаартай булшнаас хоромсогын ясан чимэг илэрчээ (Цогтбаатар нар, 2020: 131).

2018, 2019, 2020 онд Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын нутагт орших Хориг хэмээх ууланд олон тооны булш тоногдсон байсныг илрүүлэн авран хамгаалах малтлага судалгаа хийжээ. Тус оршуулгын газрын 8 булшнаас хоромсогын ясан чимэглэл олдсон байгаа нь одоогоор нэг оршуулгын газраас олдсон хамгийн олон тоотой нь болж байна. Үүнд: Хориг 1-2, 1-20, 1-28, 2-6, 2-23, 2-26, 2-27, 2-28 (Баярсайхан нар, 2023: 30, 52, 192-223) хамаарна. Мөн энэ бүс нутагт орших Доод Цахир нэртэй ууланд 2020-2023 оны хооронд ажиллан L11, L22, L46 дугаартай булшнуудаас хоромсогын хээтэй ясан чимэглэл илэрсэн байна (Хүрэлсүх нар, 2023: 73-76).

2021 онд Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг Их Оорцог уулын булшнаас мөн 1 хоромсогыг илрүүлэн олжээ (Эрдэнэболд нар, 2021: 88).

2024 онд Завхан аймгийн Яруу сумын нутагт Уушги хэмээх уулын 2-р булшнаас ясан чимэглэлтэй хоромсог гарсан байна (Очир нар, 2024: 96).

Энэхүү ясан чимэглэлтэй үйсэн хоромсогын талаар тусгайлан нэг өгүүлэл хэвлэгдсэн нь Монголын нутгаас илэрсэн 12 олдворыг Н.В.Малиновская-ын судалгаатай харьцуулан судалж “Монголын эзэнт гүрний үед гар урлалын үйлдвэрлэл, худалдаа, соёлын солилцооны сүлжээ өргөн хүрээнд хөгжиж, энэ нь “Монголын их солилцоо” буюу “Chinggis Exchange”-ийн нэгэн

хэлбэрээр илэрч байжээ. Тухайн цаг үед нүүдэлчин язгууртнууд гар урчуудын бүтээлийг хэрэглэн, тэдгээр бүтээл нь нийгмийн статусаа илэрхийлэх арга хэрэгсэл болж байсныг саадаг болон ясан чимэглэлүүдийн олон төрлийн олдвор баталж байна.” (Билгүүн 2024: 166) хэмээн дүгнэсэн байна.

Хилийн чанадад судалсан нь. Анх ясан чимэгт хоромсогыг 1950-аад оноос Оросын судлаач Л.П.Зяблин илрүүлэн судалж эхэлсэн бөгөөд түүнээс хойш олон судлаач энэ талаар судалгааны бүтээлдээ хэвлэн нийтлүүлсэн байна. Энэ талаар судлаач Н.В.Малиновская Евразийн тал нутгаас олдсон ясан чимэгт нийт 84 хоромсогыг нэгтгэн дүгнэсэн томоохон өгүүлэл хэвлүүлжээ. Ингэхдээ нийтлэгдсэн материалуудаас гадна Улсын түүхийн музей, Улсын Эрмитаж музей, Астрахань, Волгоград, Куйбышев, Саратовын орон нутгийн түүхийн музейн цуглуулга, ЗХУ-ын ШУА-ийн Археологийн хүрээлэн, ЗХУ-ын ШУА-ийн Ленинградын Археологийн хүрээлэнгийн архиваас хэвлэгдээгүй материалууд, мөн Г.Т.Ковпаненко, Е.К.Максимов, И.В.Синицын, В.П.Шилов нарын өгсөн гар бичмэлийг, мөн тайланд ороогүй, хэвлүүлээгүй байсан материалуудыг нэмж нэгтгэсэн нь нэлээд үнэ цэнтэй судалгаанд тооцогдож байна. Тэрээр судалгааны өгүүлэлдээ урд өмнө судалсан судлаачид болох С.А.Плетнева, Л.В.Алексеев, А.Ф.Медведев, Г.А.Федоров-Давыдов нарын дүгнэлтийг тоочин өөрийн үзлийг нэмэн дурдсан байна. Мөн хоромсогын ясан чимэглэл дээр сийлсэн хээ угалзыг хэлбэр дүрсээр нь цэцэг, амьтан, геометрийн хээ хэмээн ангилаад хээ угалзыг дүрсээр нь 22 төрөл, амьтадыг үйл хөдлөлөөр нь 4 төрөлд ангилсан байна. Эцэст нь дүгнэхдээ эдгээр дүрс чимэглэл, хээ угалз бол нүүдэлчдийн соёл бөгөөд харин нутгийн гар урчууд тал нутгийн дайчдад зориулж хоромсогын ясан сийлбэр хийдэг байсан нь тодорхой байна (Малиновская, 1974: 132-175) хэмээн дүгнэжээ.

В.С.Николаев Байгалын бүс нутгаас олдсон ясан чимэглэлтэй нийт 5 хоромсогыг нэгтгэн оруулсан байна. Тэдгээрийн 4 нь Байгал нуурын бүсэд хамаарах Унгинское суурины малтлагаас, үлдсэн 1 нь Ольхон бүсийн Ангинскийн III цогцолборын оршуулгын газрын 6-р булшнаас олдсон байна. Тэрээр Н.В.Малиновская-ын Алтан ордны үйлдвэр урлал хийдэг томоохон хот суурин газрыг “Тал нутагт импортлогч хот” гэдэг үзлийг дэмжээд “Байгаль нуурын бүс нутагт ч мөн адилхан нөхцөл байдал ажиглагдсан” гэжээ (Николаев, 2006: 284-298).

Алтайн Бүгд Найрамдах Улсын Кош-Агач дүүрэгт Горно-Алтайн Улсын Их Сургуулийн археологийн экспедицийн хээрийн судалгааны ажлын үеэр Кокоря тосгоны ойролцоох

археологийн эд өлгийн зүйлсийг нутгийн иргэд нээсэн тухай мэдээллийг шалгахад олдворуудыг аль хэдийн Кокоринскийн түүх, угсаатны зүйн музейд шилжүүлсэн байжээ. Түүний дотор ясан чимэглэлтэй үйсэн хоромсого илэрсэн нь нэлээд эвдэрсэн байна. Үүнийг бусад ижил төстэй олдворуудтай харьцуулан үзээд Монголын үед хамаарна хэмээн дүгнэсэн байна (Константинов, Эбель, 2017: 22). Энд ясан чимэглэлийн дээр угалз хээний төвд таван нүдэн хээг дүрсэлсэн байгаа нь онцлог байна.

1998-2000 онд Өвөр Монголын соёлын дурсгалт зүйлс, археологийн хүрээлэн Шанду хотын эргэн тойронд орших булш оршуулгын дурсгалд авран хамгаалах малтлага судалгаа хийж олон тооны булш малтан судалжээ. Үүний дотор Жэнзишань-ий оршуулгын газрын баруун хэсэгт томоохон хэмжээний малтлага судалгаа хийсний дүнд DZXM64 дугаартай булшнаас ясан хоромсогын 5 ш нимгэн хавтгай яс, 4 ш ирмэгийн даруулга яс олсон байна. Гэвч судлаачид үүрэг зориулалтыг нь олоогүй байхаас харахад хоромсого үйсэн их биеэсээ салсан байсан бололтой. Энэ дурсгалд нимгэн хавтгай ясан дээр олон давхарласан гурвалжин хээ, угалз хээ болон толгойгоо арагш эргүүлэн дээш харж буй туулайн дүрс сийлсэн байна (魏坚, 2008: 447).

Эдгээрээс харахад бидний мэдэж байгаагаар ясан сийлбэртэй нийт 114 хоромсого илрээд байна. Энэ нь одоогоор олдод байгаа олдворуудын нийт тоо биш бөгөөд бидний олж үзэж чадаагүй олон хэрэглэгдэхүүн байгаа билээ. Цаашид энэ төрлийн олдвор нэмж илрэх нь гарцаагүй юм.

Цахиурт овоон 5-р булшны ясан чимэглэлтэй хоромсого. Сүхбаатар аймгийн Уулбаян сумын нутаг Цахиурт овооны 5-р булш нь тус оршуулгын газрын зүүн хойд хэсэгт орших бөгөөд ерөнхийдөө хамгийн дээд талд байрлах булш юм. Тус оршуулгад 2 хүнийг зэрэгцүүлэн оршуулсан байх бөгөөд хоёулаа модон австай мөн эмээл, дөрөө, хутга, хоромсого, мөнгөн аяга зэргийг дагуулсан байна. Үүний баруун талын хүний зүүн гарын шууны дээд хэсэгт, зүүн гарын бугалгын дээр 17 см урт, 3 см өргөн нумын ясан наалт гарчээ. Баруун гар талд бүсэлхий орчим авсны гадна талд хээ чимэглэл бүхий нимгэн хавтгай ясаар нүүрэн талыг бүтэн бүрхсэн үйсэн хоромсого гарсан байна. Ясан чимэглэлд маш гоёмсог төрөл бүрийн хээ, амьтны дүрс сийлжээ. Хоромсогын өмнө талд 1 ш төмөр эдлэл, дотор талаас 6 ш төмөр зэв, зүүн ташаан дээрээс хоёр талын үзүүрт ясан чимэглэлтэй 1 ш төмөр хутга, хүний толгойн зүүн талаас 3 ш төмөр зэв гэх мэт зэр зэвсгийн зүйлс гарсан байна (Энхтөр нар, 2011, 11).

Хоромсого. Тус хоромсого нь 91 см урттай, 22

см өргөнтэй бөгөөд хоромсогын амсар хэсгээр улаан будагтай хавтгай модны хэсэг байна. Түүний доод талд хоромсогын амсрын ар талын дотрыг урд амсраас доош буюу хоромсогын амсраар дотогш хүний харах түвшин хүртэл хээтэй ясаар чимэглэсэн. Мөн нүүрэн талын амсрын дээд ирмэгээс доод үзүүр хүртэл ясан чимэглэлээр битүү бүрсэн байна. Үүнийг хийхдээ маш гоёмсог төрөл бүрийн хээ, амьтны дүрс ухаж сийлсэн нимгэн хавтгай яснуудыг ирмэгээр нь нийлүүлэн зүйж, тэдгээрийн хоорондох зааг дээр 1.5 см өргөнтэй урт нарийхан болгон зассан зузаавтар хээтэй ясаар амыг таглан үйсэн хоромсогод үдэж тогтоосон байна. Ясан дээр сийлсэн дүрслэлийг үзүүртэй нарийн багажаар ухаж сийлсэн ба тухайн ухлаадсыг хар өнгийн бэх мэт зүйлээр дүүргэж эрээлсэн нь хээ дүрслэлийг маш тод харагдуулах ажээ.

Ясан чимэглэл дээрх дүрслэл нь амьтан болон хээ гэсэн үндсэн хоёр төрөлтэй байна. Засаж янзалсан нэг хавтан ясны төв хэсэгт амьтны дүрс сийлээд түүнийг тойруулан угалз хээгээр хүрээлэн чимэглэх бөгөөд дүрсэлсэн амьтны эргэн тойронд ургамал навч сийлж, үлдсэн зайг тууш зураасаар дүүргэжээ. Ингэж сийлсний дараа бусад хэсэгтэй нийлэх хэсэгт олон төрлийн хээгээр давхарлаж амьтдын дүрс хоорондын заагийг гаргасан байна.

Хээ чимэглэлийг дотор нь а. байгалийн сэдэвт, б. геометрийн дүрст хэмээн ангилж болохоор байна. Үүнээс а. төрөлд үүлэн хээ, цэцгэн хээ, навчин хээ орох бол б. төрөлд нь алхан хээ, дугуй, гурвалжин, долгио зураас, шулуун зураас, босоо зураас, ташуу зураас зэргийг нэг эгнээнд ар араас нь эгнүүлэх эсвэл давхарлах зарчмаар хээлсэн байна. Гурвалжин дүрсээр хээлэхдээ хоёр ба гурван эгнээгээр давхарлах бөгөөд ингэхдээ жижиг гурвалжин цэгийг 3 ба 6-аар дээш гурвалжлах маягаар давхарлан хээлжээ. Амьтдын дүрсийг мөн дотор нь домгийн болон бодит хэмээн ангилж болохоор байна. Домгийн амьтдын төрөлд лууг нийт 6 удаа сийлсэн бол галт шувууг 1 удаа сийлсэн нь мэдэгдэх боловч түүний эсрэг талын эвдэрсэн булангийн хэсэгт ахин нэг байсан байх боломжтой юм. Бодит амьтдын төрөлд гөрөөс, туулай, хулгана, шувуу дүрсэлсэн бөгөөд эдгээр амьтан нь утга бэлгэдлийн хувьд бүгд өөр өөрсдийн сайн бэлгэдлийг агуулдаг.

Хэлэлцүүлэг

Хоромсогын нэрийн тухайд. Ихэвчлэн нүүдэлчдийн дунд өргөн хэрэглэгдэж ирсэн ховд буюу бортого (шулуун, трапец) хэлбэрийн сум агуулах савыг манай судлаачид өөр өөрөөр нэрлэж иржээ. Үүнд зарим судлаачид ховд, хоромсог нэрээр бичсэн бол ихэнх судлаачид саадаг хэмээн нэрлэсэн байна. Учир нь энэ талаар “Хорин нэгт”

зэрэг тайлбар толиудад “*Саадаг – Саарь арьс, торго бөсийн зэргийн юмыг өндөр хоёр төв илүү, өргөн нэг төв илүү хийж гадрын этгээдэд гурван нүд ухаж сум зэвийн зэргийн зэвсэг дүрэхийг нь саадаг хэмээмүй, Ховд (Обуду) – Саадгийн амсарт тавьсан зэв сум дүрэх зэрэг арьс эсгийг Обуду хэмээмүй, Хор – Арьсаар хийсэн саадгийн дотор этгээдэд хавсран хадаж, годил сэрээ дүрэхийг нь хор хэмээмүй, Хоромсог – Саарь арьс торго бөсөөр хийсэн нум дүрэхийг нь хоромсог хэмээмүй*” (Хорин нэгт..., 1979: 104-527) хэмээн бичсэнийг ихэнх судлаачид эшилдэг бололтой. Үүний нэг жишээг дор дурдвал, дараах байдалтай байна.

Зэр зэвсгийн талаар судалгаа хийдэг Ж.Базарсүрэнгийн үзсэнээр “Монголын нууц товчооны 203 дугаар зүйлд “үйилсүн хор убис кикүй-дүр” хэмээсэн нэгэн мөр байдгийн “үйилсүн хор” гэдэг нэрийн тухай” бичихдээ “Монголын нууц товчоо”-г судалсан бусад судлаачдын олон талт тайлбарыг дурдаад өөрийн саналыг дэвшүүлсэн байна. “Уг хоромсог бол хор хавсран саадаг хадсан саадаг ч биш. Анхлан нум, хор (сум) хоёрыг нэгэн саванд агуулж явдаг, түүнийгээ хор агуулдаг сав буюу “Хоромсог” гэж нэрийдэж асан тэр эрт цагийн нэр агаад хожим нь хор (сум)-оо нумаасаа тусад нь агуулах болсон хэдий ч эртний тэр л нэрээрээ нэршин үлдсэн хэрэг” гэжээ. Тэрээр мөн сум хийх савыг “саадаг” хэмээн хэлсэн ба “Монголын нууц товчоо”-нд гарч буй дээрх үгийг үйсэн хор (үйсэн сум)-ыг заана хэмээн бичжээ. Учир нь Буриадын нутаг “Харбаян (Окошки)” ууланд малтсан нэгэн монгол булшнаас мөсийг нь хушны нимгэн үйсээр хулдаж бүрсэн сум гарсныг үндэслэн ийнхүү дүгнэсэн байна (Базарсүрэн, 2003: 210-212). Мөн эрт үеийн булш оршуулгаас мөсийг нь үйсээр ороож хийсэн сум нэлээд ховорхон олдох бөгөөд ингэж хийсэн сум хэр тэсвэртэй вэ? гэх зэрэг олон асуултууд эргэлзээ төрүүлж байна.

Харин өөр нэгэн тайлбар тольд “*Хор – нум сум агуулах түрүүвч. Уул нь зэв сумыг агуулах савыг нэрлэдэг байжээ*” (Бао Шуан Лун, Баянбаатар, 2016: 554) гэснээс харахад хор, хоромсог гэдэг ойлголт эсрэгээрээ нэрлэгдэж саадаг болсон бололтой гэсэн бидний саналыг батлах бас нэгэн сэжүүр юм. “Монголын нууц товчоо”-нд “хор” гэх үг олон хувилбараар гардаг. Үүнд “хор ахсуба”, “хорчин турхаг”, “хорчи”, “хорчид”, “үйсүн хор”, “хорчин” зэрэг үгнүүд гарч байна. Эдгээр нь бүгд “хор” (сум)-той холбоотой үгс бөгөөд агуулгаараа зэвсэг, харваач, зэрэг цол, хүний нэрийг хүртэл хамааруулж байна. Мөн хор хэмээх үг үүнээс өмнө ч байсныг батлах сурвалж бол Хятадын Тан улсын сурвалж юм. Түүнд “хор” гэдэг үгийг тэмдэглэхдээ шууд галиглан “胡禄” (hulu) хэмээн

тэмдэглэсэн байна. “Hulu” гэдэг нь Тан гүрний үед *трапец хэлбэрийн, нарийхан хүзүүтэй цилиндр хэлбэртэй хоромсогыг хэлдэг тусгай нэр томъёо байв*. “Hulu” гэдэг нь харь үг бөгөөд Түрэг хэлний *Qurluq* гэдэг үгийн галиглал юм. Hulu-ийн талаарх олон тэмдэглэлийг Тан болон Таван гүрний үеийн Дунхуан, Турфаны баримт бичгээс олж болно. Жишээлбэл: *新唐书* (Тангийн шинэ түүх)-д 50-р боть, “Цэргийн хэргийн тухай туурвил”-д “Хүн бүр нэг нум, гучин сум, нэг hulu, нэг хэвтээ сэлэмтэй” гэж заасан байдаг (负琰, 2016: 130). Энд харь үгийн галиг хэмээн зөв тодорхойлсон боловч судлаач “qurluq” хэмээх түрэг үг хэмээн ташаа ойлгосон ба харин “хор” гэдэг үгийг шууд галигласан болох нь тодорхой харагдаж байна. Энэ бүх баримтаас харахад одоогийн бидний нэрлэн заншсан “хоромсог”-ыг эрт үедээ “хор” хэмээн нэрлэдэг байжээ. Харин “саадаг” гэдэг нь нумыг агсан авч явахад зориулсан гэрийг хэлж буй бололтой. “Ховд” хэмээх үг бол бортого хэлбэрийн бүхэл төрлийн саванд хэрэглэж байсан ерөнхий нэр бололтой. Бид энэ удаад хоромсогын ясан чимэглэлийн талаар голчлон авч үзэж буй учир энэ удаад бусад нэрсийн талаар энд хүрээд түр орхиж байна.

Хоромсогын ясан чимэглэл. Хоромсогын ясан чимэглэлийн хэрэглэгдэхүүн нь яг ямар амьтны яс болох талаар судлаачид хэд хэдэн санал гаргаад байна. “Бод малын дал эсвэл гавлын ясны магнай хэсгийн нимгэн ясыг хоёр талаас нь сайтар зүлгэн тэгшилж хийсэн...” (Батсайхан нар, 2015: 325), “ойролцоо бүс нутгийн ан амьтан эсвэл гэршүүлсэн малын ясыг боловсруулдаг” (Билгүүн, 2024: 162) хэмээн өөрсдийн саналыг дэвшүүлжээ.

Харин сүүлийн үед Оросын судлаачид үүнийг илүү нарийн лабораторийн түвшинд судлан шинжилсэн нь нэлээн сонирхолтой үр дүнд хүрсэн байдаг. Е.Е. Антипина 2011 онд Алтан ордны Болгар хотод хийсэн археологийн малтлагаас илэрсэн хоромсогын 4 ш нимгэн хавтгай яс, нэг урт нарийн даруулга ясыг олон төрлийн ясны элементүүдийн ясны эдийн остеон бүтцийн лавлагаа дээжтэй харьцуулж үзээд нимгэн хавтант яснууд нь зааны соёоны гадраар хийсэн, урт нарийн яс нь том, туурайтан амьтны хавирганы яс хэмээн тодорхойлсон байна. Мөн энд гар урлалын үлдэгдэл болох үйлдвэрийн хаягдал буюу алдаатай хийсэн бүтээгдэхүүнүүд олдсон байна. Эндээс ясан чимэглэлийн арай дуусаагүй хэсэг, хийсэн сийлбэртээ хар будаг түрхэж амжаагүй ясан чимэглэлүүд гарснаар ясан эдлэлийн гар урлалын урланг тодорхойлж чадсан байна. Болгар хотын төвийн энэхүү урлангаас олдсон түүхий эдийн судалгаанаас харахад олон төрлийн ясан эдлэл байх бөгөөд материал нь орон нутгийн шинжтэй амьтан, шувуу, загасны яс, ойт

хээрийн бүс нутгийн цаа буга, хандгай, бугын эврийн түүхий эдээс гадна худалдааны замаар орж ирсэн заан, далайн арслан зэрэг амьтдын соёо байжээ (Яворская, 2018: 210).

Юань улсын үед мөн зааны соёо зэргээр худалдаа наймаа хийж байсан мэдээ байдаг. Тухайн үеийн далайн аялагч бөгөөд худалдаачин Ван Даюань гэдэг хүний бичсэн “Арал хойгийн улсуудын тухай товч тэмдэглэл” хэмээх номд 100 гаруй улс оронтой худалдаа хийж байсан тухай тэмдэглэгдсэн байдаг. Өөрөөр хэлбэл Ази Африк, Европ тивтэй далайгаар худалдаа хийх ба гадаадаас оруулж байсан бараа таваар нь голдуу үнэт эдлэл, эмийн материал голлож байжээ. Жишээ нь, Ази, Африкийн улс орнуудаас шүр, сувд, тана, оюу, зааны соёо, хирсний эвэр, толботой яст мэлхий, алмас эрдэнэ, хүрэл эд, сүвмэл, паалан, агар, зандан, сум мод, үнэт материал болон эмийн ургамлыг оруулж байжээ (Пунсаг нар, 2019: 104).

Монголоос олдоод буй хоромсогын ясан чимэглэлийн түүхий эд тухайн нутагт амьдарч байсан том амьтдын яс байхаас гадна, харь орноос импортлон оруулж ирсэн зааны соёо зэрэг ховор амьтдын яс, эвэр байсныг үгүйсгэх аргагүй юм. Энэ нь Цахиурт овооноос олдсон хоромсогын ясан чимэглэлийн ясны зарим нь сийрэг бүтэцтэй байсан бол зарим яс нь илүү нягт хатуу байгаагаас харагдана. Гэвч энэ нь одоогоор зөвхөн таамаг төдий дүгнэлт бөгөөд лабораторийн нарийн шинжилгээ хийх шаардлагатай юм. Яснуудыг ажиглан үзвэл ерөнхийдөө нимгэн хавтгай яс нь илүү нягт чанартай байгаа бол нарийн урт даруулга маягаар хийсэн ясан чимэглэл нь арай сийрэг ба том амьтны (хавирга г. м.) ясаар хийдэг байсан бололтой. Амьтны эвэр, ясаар эд зүйлс хийдэг уламжлал одоо хүртэл монголчуудын дунд буйгаа бугын эврийг усанд дэвтээн зөөлрүүлсний дараа хайчилж засан эмээлийн хяр хийж байсан тухай мэдээ бий.

Монголчуудыг түүхэн сурвалжийн зурагт хээ зураг бүхий үйсэн хоромсоготойгоор дүрсэлсэн нь олон. Үүнд: Ил хаант улсын байлдан дагууллыг дүрсэлсэн зургуудад, тухайлбал 1258 онд “Монголчууд Багдадыг довтлон эзэлсэн нь” хэмээх зурагт харваачид үйсэн хоромсог зүүн харвалдах бөгөөд зүүсэн хоромсог нь амсар хэсэгтээ хээтэй ясан чимэглэлээр чимэглэсэн байна. Мөн “Монгол хааныг ширээнд залж байгаа нь” зурагт сандалтан ноёдын¹ дунд хоёр ноён чимэглэл бүхий үйсэн хоромсог зүүсэн байна. Юань улсын үеийн “Хубилай хаан гөрөөлж буй” хэмээх зурагт нэгэн морьтны зүүсэн хоромсогын төв хэсэгт, давхиж буй гөрөөс дүрсэлсэн бололтой байна (Чингис хаан..., 2010: 252-299). Энэ мэт олон

¹ Хааны ордонд сандал дээр суух тусгай эрхээр соёрхогдсон ноёд (Алтансүх, 2025: 310)



Зураг 1. а. 1258 онд “Монголчууд Багдадыг довтлон эзэлсэн нь.
б. Монгол хааныг ширээнд залж байгаа нь.

зураг дээр хоромсогыг хээ болон амьтны дүрсээр чимэглэсэн байгааг ажиглаж болно. Түүхэн зураг болон археологийн олдвор баримтаас харахад үйсэн хоромсогыг ясаар бүрэн хучиж чимэглэх, амсар болон ёроол хэсэгт, хоромсогын гуравны нэгт эсвэл зөвхөн амсар хэсэгт чимэглэдэг байсан нь харагдаж байна.

Энэхүү ясан чимэглэлт хоромсогын талаар судлаач Г.Батболд нэгэн сонирхолтой санал дэвшүүлсэн байна. “Энэхүү эдлэлийг зуутын ноёд, эсвэл түүнээс дээших ноёд ихэст зориулан ордны дэргэдэх урланд хийснийг гавьяа, шагнал болгон өгдөг байсан байж болох юм хэмээн үзэж байна. Ордон юм уу, ихсийн дэргэд тусгай гар урчууд байсныг батлах нэгэн баримт одоо Өвөр Монголын Алшаа аймгийн нутагт буй, 1227 онд Чингис хааны байлдан эзэлсэн Тангудын нийслэл болох Хар хотоос олджээ. Тэр нь урлангийн газарт хувцас захиалж даалгасан данс байна. Уг данс нь ууж дээл, богтог малгай, гутал зэргийг бүрэн чимэгтэйгээр хийж үйлдэхийг даалгасан утгатай байжээ. Үүнээс харахад ихэс дээдсийн охид харьд одох, хүнтэй суухад иж бүрэн хувцаслах, эрэлхгээр тулалдаж гавьяа байгуулсан баатар эрсэд иж бүрэн хуяг дуулга, зэр зэвсэг бэлэглэх зэрэгт зориулсан урлангийн газар байжээ хэмээн үзүүштэй” (Батболд, 2022: 137).

Юань улсын түүхэнд тэмдэглэсэнээр зэр зэвсэг хийх төрөл бүрийн газар байхаас гадна, цэргийн явдлын яамны дор ажилладаг “Нум сумны товчоо” (弓局) нэртэй, нум үйлдвэрлэдэг тасагтай байгууллага ажиллаж байжээ (Farquhar, 1976: 277). Сурвалжид гуравдугаар зэрэглэлийн албан тушаалтан даргалсан “Цэргийн хэрэгслийн товчоо” нь цэргийн хэрэгслийг засварлах, арчлах, хангамжийг хянах үүрэгтэй байв. Үүнд дөрвөн сайд (гутгаар зэрэглэлийн албан тушаалтан), зургаан туслах сайд (гутгаар зэрэглэлийн албан тушаалтан), дөрвөн дэд сайд (дөтгөөр зэрэглэлийн албан тушаалтан), дөрвөн туслах сайд (тавдугаар

зэрэглэлийн албан тушаалтан), нэг бичиг хэргийн ажилтан, нэг нарийн бичгийн дарга, нэг бүртгэл хөтлөгч, нэг агуулахын эрхлэгч, хоёр нум шалгагч, шөрмөс, эвэр, өд болон бусад хэрэгслийг шалгадаг хоёр албан тушаалтан, арван гурван бичиг хэргийн ажилтан багтжээ (元史, 1976: 2277). Тус товчоо нь хэд хэдэн шилдэг урлаачдаас бүрдсэн гар урлантай бөгөөд тэдгээр нь тухайн орон нутагтаа хийсэн зэвсэг эд хэрэгслийг “Төв товчоо”-нд нийлүүлэх бөгөөд тэндээсээ зарлиг шийдвэрийн дагуу албан ёсоор тараадаг байжээ. Үүнээс үзэхэд нум сум хийхээс гадна түүнийгээ агуулах сав буюу хоромсого, саадаг зэрэг бусад агсарга хэрэгслийг иж бүрнээр хийдэг байсан нь түүний хээ чимэглэл, дүрслэлийн ижил төстэй байдлаас харагдаж байна.

Морьтон нүүдэлчдийн ертөнцөд, ялангуяа Монголын байлдан дагууллын үеэр хоромсого нь нум, сумны иж бүрэн системийн салшгүй хэсэг байв. Трапец хэлбэрийн, хүзүүвтэй, заримдаа амны таглаатай хоромсогууд нь сумыг хамгаалах, морь унах үед аюулгүй авч явах, мөн хурдан гарган ашиглах зэрэг практик шаардлагад нийцүүлэн боловсронгуй болсон нь тодорхой харагдана. Үүн дээр нэмээд, зарим тансаг хийцтэй хоромсогууд нь эзэмшигчийн нийгмийн байр суурь, эрх мэдэл, чинээлэг байдлыг илтгэх бэлгэдлийн үүрэг гүйцэтгэж байжээ (Reisch, 2010: 136).

Хээ чимэглэл. Цахиурт овооноос илэрсэн хоромсогын ясан чимэглэл дээрх хээ, дүрсэлбэрүүдийг нэг бүрээр нь дүрслэн хэлбэл:

а. Байгаль, ургамлын дүрст хээнд: 1. Усан долгио хээ, 2. Цэцгэн хээг эгнүүлэн хийсэн хээ, 3. Угалз хээ, 4. Хамар угалз хээ зэрэг орж байна.

б. Геометрийн дүрст хээнд: 1. Гурвалжин цэгийг гурав болон зургаагаар орж гурвалжин дүрс, 2. дөрвөлжин дүрсийг олон давхарлаж үргэлжлүүлсэн, 3. Дугуй дүрсийг эгнүүлэн хийсэн, 4. Ташуу зураасаар эгнүүлсэн, 5. Алхан хээ зэрэг орж байна.

Амьтны дүрсэлбэр нь: 1. Шувуу (галт шувуу) 4, 2. Луу 6, 3. Хулгана 1, 4. Туулай 5, 5. Гөрөөс зэрэг 4 амьтныг дүрсэлсэн байх бөгөөд эдгээр амьтныг өөр өөр үйл хөдлөлөөр дүрсэлсэн нь амьтан бүр өөр хоорондоо давтагдахгүй байгааг харуулж байна. Мөн ганц Цахиурт овооны хоромсого ч биш бусад газраас олдсон ихэнх ясан чимэглэл дээрх сийлбэрлэсэн амьтад хоорондоо давхцахгүй байгаа нь харагддаг. Энэ нь ясан чимэглэлийг хийхдээ бүтдийг гараар нэг бүрчлэн хийсэн болохыг давхар гэрчилж байна.


Амьтдын дүрсэлбэр дотор домгийн амьтдын дүрсэлбэр байдаг нь язгууртны эдэлж хэрэглэх зүйл болохыг илэрхийлдэг. Луу бол дорно дахины олон үндэстний хээ угалзын дотор онцгой байр суурь эзэлдэг, соёлын хувьд урт удаан хугацаанд нийтлэг болсон зүйлийн нэг юм. Үлгэр домгийн энэ амьтны дүр Нангиадын утга соёл, дүрслэх урлагийн дурсгалд нэн их түгсэн бөгөөд лууг гол усны эзэн хэмээн онцгой шүтэн биширдэг ажээ. Луу нь эзэн хаан, хаант төрийн бэлгэ тэмдэг болох тул хааны ураг төрлийнхний хувцас эдлэлд луу дүрсэлдэг байв (Эрдэнэбат, 2023: 127). Мөн үлгэр домгийн энэ амьтны дүр Монголын утга соёлд гүн гүнзгий нэвтэрч, дүрслэх урлагийн бүтээл төдийгүй ардын аман зохиол, баатарлаг туульсын дотор эзэн хааны эрх сүр, баатар эрийн хүч чадлыг илтгэх бэлэг тэмдэг болон орсон нь олон зүйлээр илэрдэг (Баяр, 2000: 18).

Домгийн амьтдын дүрсэлбэр дотор мөн эрх мэдэл, сүр хүчийг бэлгэдсэн галт шувууг дүрсэлсэн байна. Энэхүү домгийн шувууны дүрслэл нүүдэлчдийн дунд анх хэдийнээс орж ирсэн нь тодорхойгүй боловч археологийн баримтаас үзэхэд Түрэгийн үеийн эд өлгийн зүйлс дээр байгаа нь харагддаг. Энэ нь мөн тэдний хөрш зэргэлдээ улс болох Сүй, Тан улсын үеийн эдлэл хэрэглэл дээр дүрслэгдэж ирсэнтэй холбоотой бололтой. Галт шувууны нэрийн талаар судлаач

Өргөндалай энэ нь “Гарди” шувуу болов уу хэмээн өөрийн саналыг хэлсэн байна (Цан хай, 2025: 100). Тэрээр мөн “Уламжлалт ярианд, Гарди бол шувуудын төрлийн хаан байж, эртний Хятад улсын хааны эрх ямбаны бэлгэдэл болж байжээ. “Хуа и юй” толийн араатан жигүүртний бүлэгт “凤凰”(feng huang) гэх Хятад үгийг “Хангарьд” хэмээн орчуулжээ. Гарди буюу Хангарди нь эрэгчин, Галбинга гэдэг нь эмэгчин, ерийн үгэнд хоёулыг хамтад нь Гарди хэмээнэ” (Цан хай, 2025: 101) гэсэн байна. Галт шувуу нэрийг харин хэзээнээс хэрэглэж ирсэн нь мэдэгдэхгүй бөгөөд магадгүй хуучны Орос ардын үлгэр домогт гал мэт гэрэл цацруулдаг хэмээн гардгаас үүдэлтэй нэр байж болох юм.

Үүнээс үзэхэд ясан чимэглэлт үйсэн хоромсого дээр дүрсэлсэн эдгээр луу, галт шувуу зэргийг язгууртны эдлэл хэрэглэл дээр дүрслэх бөгөөд магадгүй ийм эдлэл хэрэглэлээр бусдаас ялгарч, мөн тэднийг таньж хүндлэн харьцдаг байсан бололтой. Ийм дүрсэлбэрийг ганц энэхүү хоромсогоын ясан чимэглэл дээр дүрслээгүй. Харин яг үүнтэй ижил дүрслэлээр эмээлийн бүүрэг дээрх алт мөнгөн ялтас, хувцас, бусад гоёл чимэглэл, эдлэл хэрэглэл, ордны барилгын чимэглэлийг хээлэн чимэглэж байжээ.

Хээ чимэглэлийн хувьд нүүдэлчдийн уламжлалт соёлын нэгэн хэлбэр болох нь Хүннү, Түрэг, Уйгур зэрэг эртний улсуудын үеийн эдийн соёлд тусгагдсан байдлаас харагддаг билээ. Мөн XX зууны угсаатны зүйн мэдээнд “дүрсээр бэлгэдэх нь монголчуудын эдийн болон оюуны соёлын нэгэн чухал хэсэг юм. Дүрсээр бэлгэдэх нь манай ардын зан үйл, хээ угалз, уяа зангилаа, мал маллагааны зэрэг нийгмийн болон өдөр тутмын үйл ажиллагааны олон хэлбэрт тодорхой шингэсэн байдаг. Дүрсээр бэлгэдэхэд байгалийн бодит дүрс болох нар, сар, уул, ус, мод, чулуу, мөн буга, мал, нохой, шувуу мэтийн олон амьтныг дүрсэлдэг”



Зураг 2. Цахиурт овооны ясан сийлбэрт хоромсого дээрх галт шувуу, лууны дүрслэл

(Бадамхатан нар, 2012: 236). Энэ мэт мэдээнээс харахад энэ төрлийн хээ дүрсийн чимэглэл бол нүүдэлчдийн оюун санааны онцлогтой холбоотой бололтой.

Хээтэй ясан чимэглэл одоогийн байдлаар Монгол улсын нутгаас 25, ОХУ-ын Байгал орчмын бүс нутгаас 5, Алтайн БНУ-ын нутгаас 1, хуучнаар Алтан Ордны улсын нутгаас 84 илрээд байгаа бөгөөд эдгээрээс гадна бидний үзэж амжаагүй хэд хэдэн дурсгал байна. Дүрсэлбэрийн хувьд нутаг нутгийн онцлогоос шалтгаалж өөр өөр байгаа нь ийм хоромсогыг зөвхөн нэг газар хийдэггүй, олон газарт хийж байсныг харуулж байна.

Ерөнхий зураглалаар харвал хангайгаас урагш тал хээрийн бүс нутгаас илэрсэн ясан чимэг дээр туулай, хулгана, гөрөөс, мөн зэрэг зиндаанаас хамаарч луу, галт шувуу зэргийг дүрсэлдэг бол уулархаг муж нутгуудад ихэвчлэн буга, согоо, хандгай, янгир, таван нүдэн хээ зэргийг голлуулан зурсан байна.

Харин баруунш Алтан Ордны улсын нутгаас олдож буй чимэглэлийн дүрсэлбэрт цаа буга, хандгай, буга, ирвэс, хүн, янгир, гөрөөс, морьтой хүн, шувуу, туулай, луу зэргийг дүрсэлсэн байна (Малиновская, 1974: 146-168). Энд голын дүрсэлбэр болон хээ чимэглэлийн хувьд нэлээд олон төрөл болсон байх ба хүн болон махчин амьтны дүрсэлбэр шинээр нэмэгдсэн нь баруун зүгийн аян дайны үед олон овгийн үндэстэн ястан нүүдэлчид нэгдэн холилдсонтой холбоотой бололтой. Учир нь нүүдэлчдийн хувьд хээ дүрсний бэлгэдэл нь тэдний өсөж төрсөн орчин

нөхцөл, ахуй амьдралтай шууд хамаатай болох нь харагдаж байна.

Он цаг. Судлаачид энэ төрлийн ясан чимэг бүхий хоромсого илэрч буй булшийг XIII-XIV зуун хэмээн үздэг бөгөөд булшнаас илэрч буй бусад олдвор ч үүнийг давхар гэрчилдэг. Цахиурт овооны бүлэг оршуулгын газарт малтсан булшнаас бидний өгүүлэн буй 5-р булшинд он цаг тогтоох (C¹⁴) шинжилгээ хийж чадаагүй боловч ойролцоох 18-р булшинд хийхэд Юань улсын үеийг заасан ба эдгээр бүлэг булш оршуулгын зан үйл, олдсон эд өлгийн зүйлсээрээ нэгэн цаг үеийнх болох нь харагддаг. Он цагийн хувьд алдарт Онгон сумын Таван толгойн язгууртны оршуулгын газартай ижил байна. Мөн сүүлийн үед малтан судлаад буй Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын нутаг Хориг уулын булшинд малтлага судалгаа хийн Хориг 1-т орших бүлэг булшнаас 5 булшинд он цаг тогтоох дээж шинжлүүлэхэд ерөнхийдөө 1170-1452 (Баярсайхан нар, 2023: 62) оны хооронд холбогдохыг тогтоогоод байна.

Харин харьцангуй эрт хэмээн үзэж буй хоёр дурсгалын нэг нь Ханзат бөгөөд үүнд он цаг шинжлүүлэх дээж хараахан хийгээгүй боловч хамт илэрсэн олдвор хэрэглэгдэхүүнээр нь “(XI-XII зуун) үед хамаарч магадгүй хэмээн үзсэн бөгөөд цаашид лабораторийн шинжилгээний үр дүнгээр он цагийн хамаарлыг тогтооно” (Цогтбаатар нар, 2020: 131) гэжээ. Бидний үзэхэд энэхүү сийлбэртэй ясан чимэглэл бүхий хоромсого нь XIII-XIV зууны үед буюу тодруулбал Юань улсын үед холбогдох нь гарцаагүй хэмээн үзэж байна.

Хүснэгт 1: Монголоос илэрсэн хоромсогын сийлбэртэй ясан чимэглэлүүдийн харьцуулалт

Д/д	Олдсон газар	Аймаг сум	Булшны дугаар	Голын дүрслэл	Хээ	Хоромсогын аль хэсэгт
1	Саран толгой	Увс аймгийн Зүүнговь сум	-	Туулай	Хамар угалз Угалз Геометр	-
2	Таван толгой	Сүхбаатар аймгийн Онгон сум	11	Туулай	Хамар угалз Угалз Геометр	Бүрэн
3	Таван толгой	Сүхбаатар аймгийн Онгон сум	59	Шувуу 2 Луу 4	Долгио Угалз Геометр	-
4	Цахиурт овоо	Сүхбаатар аймгийн Уулбаян сум	5	Шувуу 4 Луу 6 Хулгана 1 Туулай 5 Гөрөөс 4	Хамар угалз Угалз Геометр Алхан Долгио Цэцгэн	Бүрэн
5	Оорцог овоо	Сүхбаатар аймгийн Түвшинширээ сум	?	Хулгана 2	Хамар угалз Сүлжмэл Геометр	Амсар хэсгийн 3/1
6	Ухаа худаг	Өмнөговь аймгийн Цогтцэций сум	9	-		-
7	Жавхлант орд	Өмнөговь аймгийн Гурван тэс сум	6	-	Цагариг	-

8	Чандмань хар уул	Дорноговь аймгийн Дэлгэрэх сум	77	Гөрөөс 2	Хамар угалз Долгио	Амсар хэсгийн 3/1
9	Чандмань хар уул	Дорноговь аймгийн Дэлгэрэх сум	216	-	Зураас Цэг Чандмань	-
10	Баруун цагаан дэл уул	Дорноговь аймгийн Айраг сум	21	-	Угалз Долгио	-
11	Таван толгой	Өмнөговь аймгийн Цогтцэций сум	ЕТТ6	-	Алхан	-
12	Таван толгой	Өмнөговь аймгийн Цогтцэций сум	ЕТТ10	Туулай	Алхан	-
13	Доод цахир	Хөвсгөл аймгийн Улаан-Уул сум	L11	Буга 4	Геометр	-
14	Доод цахир	Хөвсгөл аймгийн Улаан-Уул сум	L22	?	-	-
15	Доод цахир	Хөвсгөл аймгийн Улаан-Уул сум	L46	Хандгай	-	-
16	Хориг	Хөвсгөл аймгийн Улаан-Уул сум	1-2	Согоо 2 Цэцэг 2	Геометр Угалз	Бүрэн
17	Хориг	Хөвсгөл аймгийн Улаан-Уул сум	1-20	-	Угалз	-
18	Хориг	Хөвсгөл аймгийн Улаан-Уул сум	1-28	Шувуу	Таван нүдэн Угалз	-
19	Хориг	Хөвсгөл аймгийн Улаан-Уул сум	2-6	Хандгай 5	Геометр	-
20	Хориг	Хөвсгөл аймгийн Улаан-Уул сум	2-23	Хандгай Таван нүдэн	Геометр	-
21	Хориг	Хөвсгөл аймгийн Улаан-Уул сум	2-26	Хандгай ?	Геометр	-
22	Хориг	Хөвсгөл аймгийн Улаан-Уул сум	2-27	Янгир ?	Геометр Таван нүдэн Угалз Алхан	-
23	Хориг	Хөвсгөл аймгийн Улаан-Уул сум	2-28	-	Таван нүдэн Угалз	-
24	Ханзат	Хэнтий аймгийн Дэлгэрхаан сум	4	Буга согоо	Хамар угалз Геометр	-
25	Уушги	Завхан аймгийн Яруу сум	2	Буга Согоо 2	Алхан Чандмань	-

Дүгнэлт

Сум агуулах савыг нэрлэж ирсэн нэрийн талаар судлаачид гурван янзын саналтай байна. Тэр гурван нэрээс бид “хоромсого” хэмээх нэрээр нэрлэхийг санал болгож байна. Учир нь түүхэн сурвалж бичгүүдэд чухам энэхүү нэрээр нэрлэсэн байх бөгөөд харин Манж Дайчин улсын сүүл үед зохиогдсон нэр томъёоны тольд хоёр нэрийг эсрэгээр нь сольж бичсэн бололтой.

Цахиурт овооны 5-р булшнаас олдсон энэхүү сийлбэртэй ясаар бүрэн чимэглэсэн хоромсогойн хээ дүрслэлүүд нь өөр өөрсдийн гэсэн утга бэлгэдлийг агуулсан, эдийн болон оюуны соёлын төлөөлөл юм. Үүнтэй ижил төрлийн ясан чимэглэл бүхий үйсэн хоромсого Евразийн төв нутгаар өргөн тархсан ба энэ нь XIII-XVI зууны үеийн монголчуудын оршуулгын дурсгалаас илэрдэг. Энэ төрлийн хоромсого бол хүн болгонд байхгүй тансаг зэрэглэлийн эдлэл бөгөөд зөвхөн чинээлэг

язгууртан болон гавьяа байгуулсан баатарлаг эрс, эсвэл мэргэн харваачдад шагнал болгон өгдөг байсан бололтой. Одоогоор бидний нэгтгэн авч үзсэн нийт 115 хоромсогойн сийлбэртэй ясан чимэглэлүүдийн хээ дүрслэл нь ерөнхий хэв загвар, дүрслэлбэрийн агуулга, арга технологи адил боловч хээ чимэглэлийн зохион байгуулалт, амьтдын дүрслэл, тэдний үйл хөдлөл нь хоорондоо давхцал үгүй, бүгд өөр өөр болох нь харагддаг.

Нүүдэлчдийн ахуй амьдрал, зан заншилтай салшгүй холбоотой мал амьтны гаралтай ясан эдлэл боловсруулах аж ахуйн хөгжингүй үе нь XIII-XIV зууны үеийн монголчуудын байлдан дагууллын үетэй давхцах бөгөөд үүнийг дагасан худалдаа наймаатай шууд холбоотой бололтой. Цахиурт овооны оршуулгаас илэрсэнтэй ижил хоромсогойн нүүрэн талыг бүхэлд нь ясан чимэглэлээр бүрсэн хоёр тохиолдол байх ба харин харамсалтай нь энэ

үеийн ихэнх булш тоногдож эвдэгдсэн байдалтай илэрдэг бөгөөд бүрэн чимэглэлтэй хоромсого илүү олон тоотой байсан нь мэдэгддэг. Жишээ нь Таван толгойн 11 булшнаас илэрсэн бөгөөд хоромсогоос ихэнх хэсэг нь хуурч унасан боловч бүтэн байсныг гэрчлэх хэмжээгээр үйсэн хоромсогын энд тэнд наалдан үлдсэн нь харагдаж байна. Харин Таван толгойн 59-р булшнаас хэд хэдэн хагархай хэсэг илэрсэн боловч яг бүтэн байсан гэх баримт үлдээгүй байна. Нөгөө нэг нь Хориг 1-2-р булшнаас илэрсэн ясан чимэг байна. Харамсалтай нь эндэхийн булшнуудыг саяхан толгой дараалан тоносон бөгөөд чухам хэдэд нь бүрэн бүрхсэн ясан чимэглэл байсныг тогтоох боломжгүй болсон ажээ. Харин дурдсан булшнаас илэрсэн 2 ш нимгэн хавтгай яс нь хоорондоо нийлж хоромсогын доод талыг бүрхдэг байсан бололтой.

Одоогоор бидний нэгтгэн авч үзсэн хоромсогын ясан чимэглэл ерөнхий хэв загвар, хээ угалз, дүрсэлбэр зэрэг агуулга, арга технологиор адилхан боловч хээ чимэглэлийн зохион байгуулалт, амьтдын дүрсэлбэр зэргээр бүгд өөр болох нь мэдэгдэж байна. Харин бүс нутгийн хувьд бага зэрэг өөрчлөлт орсон бөгөөд ерөнхий агуулга, зургийн дүрсэлбэрээр нь 3 бүсэд, үүнд 1. тал хээрийн бүс нутаг, 2. ойт хээрийн бүс нутаг, 3. Евроазийн бүс нутгийн гэж хуваан үзэж болохоор байна. Эдгээр дотор Юань улсын тал нутгийн бүсэд үйлдсэн ясан чимэглэл нь илүү гоёмсог бөгөөд уран нарийн хийцтэй ба тэдгээр дүрслэл нь хоромсого, эмээл зэрэг өдөр тутмын хэрэгцээт эд өлгийн зүйлсийг чимэглэдэг байжээ. Харин Евроазийн бүс нутгаас илэрсэн ясан чимэглэлийн хээ дүрс нь холимог шинжтэй болж ирсэн нь байлдан дагууллын үед газар газрын шилдэг баатрууд цугласан түүхэн явдлыг батлах мэт харагдаж байна.

Цахиурт овооноос илэрсэн ясан чимэглэлд хаад язгууртны эрх ямба сүр хүчний бэлгэдэл болсон домгийн амьтдын дүрсийг сийлсэн нь энгийн нэгэн баатрын хэрэглэл биш бөгөөд харин уг булш нь алтан ургийн язгууртных байсныг илтгэж байна.

НОМ ЗҮЙ

Алтансүх Г. “Исэр” суудал. Монголын эзэнт гүрэн. *Их Юань улс ба Монгол дахь археологийн судалгаа*. УБ., 2025: 310.

Амартүвшин Ч., Батболд Н., Эрэгзэн Г., Батдалай Б. *Чандмань Хар уулын археологийн дурсгал I*. Улаанбаатар, 2015: 218-226, 251-252.

Амартүвшин Ч., Батдалай Б., Бөхчулуун Б. “Жавхлант орд” ХХК-ийн Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших уурхайн дэд бүтцийн бүрдэл болох 18 км авто замын дагууд

хийсэн археологийн авран хамгаалах малтлага судалгааны тайлан. Улаанбаатар, 2016: 42-61. АХГБСХ.

Амартүвшин Ч., Галдан Г., Бөхчулуун Б., Батдалай Б. Говийн бүсэд малтан шинжилсэн зарим монгол булшнууд. // *Археологийн судлал. Боть XXXII, Дэвтэр I-20*. Улаанбаатар, 2012: 298-324.

Бадамхатан С., Цэрэнханд Г., Батнасан Г., Аюуш Ц., Дисан Т., Тангад Д., Нансалмаа Д., Отгонбаатар Б. *Монгол улсын угсаатны зүй. Нэгдүгээр боть. Халхын угсаатны зүй (XIX-XX зууны зааг үе). Нэмэн засварласан хоёр дахь хэвлэл*. Улаанбаатар, 2012: 236.

Базарсүрэн Ж. Үйсэн хор. *Археологийн судлал. Боть XXI, Дэвтэр II*, Улаанбаатар, 2003: 110-112.

Бао Шуан Лун, Баянбаатар. *Сурагчийн монгол хэлний олон хэрэгцээт толь*. Өвөр Монголын хэвлэлийн бүлэглэл, Өвөр Монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо, 2016: 554.

Батболд Г. Монгол нохойн түүх археологийн судалгаа. “*Монголын археологийн шинэ судалгаа*” цуврал – VIII. Улаанбаатар, 2022: 137.

Батсайхан З., Амарбилэг Ч., Содномжамц Д., Баяндэлгэр Ч. Баруун Цагаан Дэл ууланд малтан судалсан монгол булшны тухайд. *Археологийн судлал. Боть XXXV, Дэвтэр 31*, Улаанбаатар, 2015: 454-482.

Баяр Д. *Алтан ургийн язгууртны нэгэн булшийг судалсан нь*. Улаанбаатар, 2000: 18.

Баярсайхан Ж., Кларк Ж., Түвшинжаргал Т., Бямбадорж Б., Бямбажаргал Б., Содномжамц Д. *Хориг уулын эрдэнэс*. Улаанбаатар, 2023: 30-52.

Билгүүн Э. Нүүдэлчдийн саадгийн ясан чимэглэл (XIII-XV зуун). *Чингис хааны өв, соёл судлал. Т. III, f. 9*, Улаанбаатар, 2024: 158-169.

Константинов Н.А., Эбель А.В. Новые находки Монгольского времени из юго-восточного Алтая (предварительное сообщение). *Теория и практика археологических исследований. Том. 18, № 2*. 2017: 22-29. [https://doi.org/10.14258/tpai\(2017\)2\(18\).-02](https://doi.org/10.14258/tpai(2017)2(18).-02)

Лхагвасүрэн Х. *Монголын археологи. (Чингэс хааны үе)*. Тэргүүн дэвтэр. Улаанбаатар, 2007: 107.

Малиновская Н.В. Колчаны XIII-XIV вв. с костяными орнаментированными обкладками на территории евразийских степей. *Города поволжья в средние века*. М., 1974: 132-175.

Наваан Д. *Бүтээл туурвилын эмхэтгэл. II Боть. Эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл, дурсамж*. Улаанбаатар, 2018: 108.

Николаев В.С. Колчаны кочевников предбайкалья и прибайкалья в XII-XIV вв. *Известия Лаборатории древних технологий. ИрГТУ вып. 4*, 2006: 284-298.

Очир Б., Мөнхдэлгэр Ж., Гүнчин-Иш Ц., Очирпүрэв У. Завхан аймгийн Яруу сумын нутаг Тахилт, Уушгит явуулсан монгол булшны малтлага

судалгааны урьдчилсан үр дүн. *Монголын археологи* 2024. Улаанбаатар, 2024: 94-98.

Өлзийбаяр С., Наваан Д., Эрдэнэ М. Сүхбаатар аймгийн нутагт хийсэн археологийн судалгаа (2007). *Mongolian Journal of Anthropology, Archaeology and Ethnology. Vol. 3, № 1*(287). Улаанбаатар, 2007: 60-76.

Пунсаг А., Наран Д., Мөнхцэцэг Т., Ганболд Ж. *Монголын Юань улс. Монголын эзэнт улсын түүх – II*. Улаанбаатар, 2019: 104.

Төрбат Ц., Батсүх Д., Баярхүү Н. 2010 онд Сүхбаатар аймгийн Онгон сумын Таван толгойд ажилласан авран хамгаалах малтлагын тайлан. Улаанбаатар, 2010: 34. АХГБСХ.

Хорин нэгт тайлбар толь. Өвөр Монголын Монгол хэл, утга зохиол, түүх судлах газар эмхлэв. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 1979: 104-527.

Хүрэлсүх С., Баярсайхан Ж., Эрэгзэн Г., Миллер А.В., Кларк Ж., Миллер Б., Баяндэлгэр Ч., Эрдэнэцэцэг Р. Доод Цахир уулын Монголын эзэнт гүрний үеийн оршуулгын газар. *Археологийн судлал. Боть XLIII, Дэвтэр 8*, Улаанбаатар, 2023: 73-76.

Цан хай (Өргөндалай). Түрэгийн хожуу улсын хааны угсааны титэм, түүний уламжлал, соёлын тухайд. *Mongolian Journal of Anthropology, Archaeology and Ethnology. Vol. 14 (2)* Улаанбаатар, 2025: 100-101.

Цогтбаатар Б., Батболд Г., Базаргүр Д., Болдхуяг До., Бүрэнтөгс Л. Хэрлэнбаян-Улаан уулын Ханзатын монгол булшны малтлага судалгааны зарим үр дүнгээс. *Монголын археологи. 2020*. Улаанбаатар, 2020: 127-132.

Цэнд гүнгийн орчуулсан Монголын Нууц Товчоон тайлбарт эх. боть I, II, III. Улаанбаатар, 2022.

Чингис хаан ба түүнийг залгамжлагчид. *Үзэсгэлэнгийн каталог*. Улаанбаатар, 2010: 252-299.

Энхтөр А., Хүрэлсүх С., Мөнхбаяр Л., Буянхшиг Ц. Сүхбаатар аймгийн Уулбаян сумын нутаг Цахиурт овоо дахь “Эм Эл Цахиурт Овоо” ХХК-ийн ашиглалтын талбайд гүйцэтгэсэн археологийн авран хамгаалах малтлага, судалгааны ажлын тайлан. Улаанбаатар, 2011: 11. АХГБСХ.

Эрдэнэбат У. Дундад зууны монголчуудын алтан эмээлийн тухай. *Mongolian journal of Anthropology, Archaeology, and Ethnology. Vol. 12 (I)*, Улаанбаатар, 2023: 124-146. <https://doi.org/10.22353/mjaae.2023120101>

Эрдэнэболд Л., Эрдэнэ Ж., Болормаа С., Ариунболд Г., Гантогтох Г. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг Оорцог Овоо ууланд хийсэн археологийн малтлага судалгааны ажлын

2021 оны товч мэдээлэл. Монголын археологи. Улаанбаатар, 2021: 88.

Эрэгзэн Г., Бөхчулуун Д., Ангарагдөлгөөн Д. “Эрдэнэс таван толгойн” ХК-ийн Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дахь тусгай зөвшөөрлийн талбай. Археологийн авран хамгаалах тайлан. Улаанбаатар, 2013: 33-55. АХГБСХ.

Яворская Л.В. Экзотическое сырье костяных артефактов из раскопок золотоордынских городов // *Вестник Волгоградского государственного университета. Серия 4, История. Регионоведение. Международные отношения. Т. 23, № 3*, 2018: 206-217. <https://doi.org/10.15688/jvolsu4.2018.3.18>

David M. Farquhar. *The government of China under Mongolian rule: A Reference Guide*. (Münchener Ostasiatische Studien, Bd. 53.) Stuttgart: Franz Steiner Verlag GmbH, 1990: 594.

Holger Riesch. Mongolische Pfeilkocher des Mittelalters. Waffen-und Kostumkunde. *Jahrgang Heft 2. 2010*: 113-148.

元史。卷九十。志第四十。百官六。1976 : 2277

袁琰。唐代射箭装备“胡禄”源流再考。体育文化导刊 2018 年5 月 第5 期: 130-135

魏坚。元上都。(上)北京: 中国大白科全书出版社, 2008.4: 447

REFERENCES

Altansukh G. “Iser” suudal. Mongolyn ezent güren. Ikh Yuani uls ba mongol dakhi arkhyeologiin sudalgaa. Ulaanbaatar, 2025: 310.

Amartüvshin Ch., Batbold N., Eregzen G, Batdalai B. Chandmani khar uulyn arkhyeologiin dursgal I. Ulaanbaatar, 2015: 218-226, 251-252.

Amartüvshin Ch., Batdalai B., Bökhchuluun B. “Javkhlant ord” KhKhK-ийн Өмнөговь аймгийн Гурвантес сумын нутагт орших уурхайн дэд бүтцийн бүрдэл болж 18 км авто замын дагууд хийсэн археологиин авран хамгаалах малтлага судалгааны тайлан. Улаанбаатар, 2016: 42-61. AKhGBSKh.

Amartüvshin Ch., Galdan G., Bökhchuluun B., Batdalai B. Goviin бүсэд малтан шинжилсэн зарим монгол булшнууд. Arkhyeologiin sudlal. Boti XXXII, Devter 1-20, Ulaanbaatar, 2012: 298-324.

Badamkhatan S., Tserenkhand G., Batnasan G., Ayuush Ts., Disan T., Tangad D., Nansalma D., Otgonbaatar B. Mongol ulsyn ugsaatny züi. Negdüger boti. Khalkhyn ugsaatny züi (XIX-XX зууны зааг үе). Nemen zasvarlasan khoyor dakhi khevel. Ulaanbaatar, 2012: 236.

Bazarsüren J. Üisen khor. Arkhyeologiin sudlal. Boti XXI, Devter 11, UB., 2003: 110-112.

Bao Shuan Lun, Bayanbaatar. Suragchiin mongol

khelnii olon kheregtseet toli. Övör Mongolyn khevleliin бүлэглэл, Övör Mongolyn surgan khümüüjliin khevleliin khoroo. 2016: 554.

Batbold G. Mongol nokhoin түүхч архыеологиин судалгаа. “Mongolyn архыеологиин shine судалгаа” tsuvral – VIII. Ulaanbaatar, 2022: 137.

Batsaikhan Z., Amarbileg Ch., Sodnomjamts D., Bayandelger Ch. Baruun Tsagaan Del uuland maltan sudalsan mongol bulshny tukhaid. Arkhyeologiin sudlal. Boti XXXV, Devter 31, Ulaanbaatar, 2015: 454-482.

Bayar D. Altan urgiin yazguurny negen bulshiig sudalsan ni. Ulaanbaatar, 2000: 18.

Bayarsaikhan J., Clark J., Tüvshinjargal T., Byambadorj B., Byambajargal B., Sodnomjamts D. Khorig uulyn erdenes. Ulaanbaatar, 2023: 30-52.

Bilgüün E. Nüüdelchdiin saadgiin yasan chimeglel (XIII-XV zuun). Chingis khaany öv, soyol sudlal. T. III, f 9. Ulaanbaatar, 2024: 158-169.

Konstantinov N.A., Ebyel A.V. Novii nakhodki Mongolskogo vremeni iz yugo vostochnogo Altay (predvaritelnoy soobshenie) teoriya practica arhayologicheskikh issledovaniy. Boti 18, № 2, 2017: 22-29. [https://doi.org/10.14258/tpai\(2017\)2\(18\).-02](https://doi.org/10.14258/tpai(2017)2(18).-02)

Lkhagvasuren Kh. Mongolyn архыеологи. (Chingis khaany üye). Terguun dewter. Ulaanbaatar, 2007: 107.

Malinovskaya N.V. Kolchany XIII-XIV vv. s kosyaniimy ornamentirovannimi obkladkami na territorii yevraziiskikh stepei. Goroda povoliya v srednie veka. Moskva., 1974: 132–175.

Navaan D. Бүтээл туурвилын эмхэтгэл. II Bot. Erdem shinjilgeenii oguulel, niitlel, dursamj. Ulaanbaatar, 2018: 108.

Nikolayev V.S. Kolchanii kochevnikov predbaikalia v XII-XIV vv. Izvestiya Laboratorii drevnih tehnologii IrGTU vip. 4, 2006: 284–298.

Ochir B., Munkhdelger J., Gunchin-Ish Ts., Ochirpurev U. Zavkhan aimgiin Yaruu sumyn nutag Takhilt, Uushgit yavuulsan mongol bulshny maltlaga sudalgaanii uridchilsan ur dün. Mongolyn архыеологи 2024. Ulaanbaatar, 2024: 94-98.

Ulziibayar S., Navaan D., Erdene M. Sukhbaatar aimgiin nutagt khiisen архыеологиин судалгаа (2007). Mongolian Journal of Anthropology, Archaeology and Ethnology, Vol. 3, № 1(287), Ulaanbaatar, 2007: 60-76.

Punsag A., Naran D., Mönkhtsetseg T., Ganbold J. Mongolyn Yuani uls. Mongolyn ezent ulsiin түүх – II. Ulaanbaatar, 2019: 104.

Turbat Ts., Batsükh D., Bayarkhuu N. 2010 ond Sühbaatar aimgiin Ongon sumyn Tavan tolgoi ajillasan avran khamgaalakh maltlaga tailan. Ulaanbaatar, 2010: 34. AKhGBSKh.

Khorin negt tailbar toli. Uvur Mongoliin Mongol khel, utga zokhiol, түүхч судлах газар emkhlev. Uvur Mongolyn Ardyn khevleliin khoroo. 1979: 104-527.

Khürelsükh S., Bayarsaikhan J., Eregzen G., Miller A.V., Clark J., Miller B., Bayandelger Ch., Erdenetsetseg R. Dood Tsakhir uulyn Mongolyn ezent günnii üyeiin orshuulgyn gazar. Arkhyeologiin sudlal. Boti XLIII, devter 8, Ulaanbaatar, 2023: 73-76.

Tsan khai (Örgöndalai). Türegiin khojuu ulsyn khaany ugsaany titem, түүнii ulamjlal, soyolyn tukhaid. Mongolian Journal of Anthropology, Archaeology and Ethnology. Vol. 14 (2), Ulaanbaatar, 2025:100-101.

Tsogtbaatar B., Batbold G., Bazargur D., Boldkhuyag Do., Burentugs L. Kherlenbayan-Ulaan uulyn Khanzatyn mongol bulshny maltlaga sudalgaany zarim ür дүнgees. Mongolyn архыеологи. Ulaanbaatar, 2020: 127-132.

Tsend güngiin orchuulsan Mongolyn Nuuts Tovchoon tailbart ekh. boti I, II, III. Ulaanbaatar, 2022.

Chingis khaan ba түүниг zalgamjlagchid. Üzesgelengiin katalogi. Ulaanbaatar, 2010: 252-299.

Enkhtur A., Khurelsukh S., Munkhbayer L., Buyankhishig Ts. Sühbaatar aimgiin Uulbayan sumyn nutag Tsakhiurt ovoo dakhi “ML Tsakhiurt Ovoo” KhKhK-iin ashigaltyn talbaid güitsetgesen архыеологиин авран khamgaalakh maltlaga, sudalgaany ajlyn tailan. Ulaanbaatar, 2011: 11. AKhGBSKh.

Erdenebat U. Dundad zuuny mongolchuudyn altan emeeliin tukhai. Mongolian journal of Anthropology, Archaeology, and Ethnology. vol 12 (1), Ulaanbaatar, 2023: 124-146. <https://doi.org/10.22353/mjaae.2023120101>

Erdenebold L., Erdene J., Bolormaa S., Ariunbold G., Gantogtokh G. Sühbaatar aimgiin Tüvshinshree sumyn nutag Oortsog Ovoo uuland khiisen архыеологиин maltlaga sudalgaany ajlyn 2021 ony товч medeelel. Mongolyn архыеологи. 2021. Ulaanbaatar, 2021: 88.

Eregzen G., Bukhchuluun D., Angaragdulguun D. “Erdenes tavan tolgoi” KhK-iin Ömnögovii aimgiin Tsogttsetsii sumyn nutag dakhi tusgai zövshöörliin talbai. Arkhyeologiin avran khamgaalakh tailan. Ulaanbaatar, 2013: 33-55. AKhGBSKh.

Yavorskaya L.V. Ekzoticheskiye syriye kostyanykh artyefaktov iz raskopok zolotoordynskikh gorodov // Vyestnik Volgogradskogo gosudarstvennogo univversityeta. Syeriya 4, Istoriya. Ryegionovyyedyniye. Myejdunarodnyye otnosheniya. T. 23, № 3, 2018: 206–217. <https://doi.org/10.15688/jvolsu4.2018.3.18>

David M. Farquhar. The government of China under Mongolian rule: A Reference Guide. (Münchener Ostasiatische Studien, Bd. 53.) Stuttgart: Franz Steiner Verlag GmbH, 1990: 594.

Holger Riesch. Mongolische Pfeilkocher des

Mittelalters. Waffen-und Kostumkunde. Jahrgang Heft 2. 2010: 113-148.

Yuánshǐ. Juǎn jiǔshí. Zhì dì sìshí. Bǎi guān liù. 1976: 2277.


Yuán yǎn. Táng dài shèjiàn zhuāngbèi “hú lù”

yuánliú zàikǎo. Tǐyù wénhuà dǎo kān 2018 Nián 5 yuè dì 5 qī: 130-135.

Wèi jiān. Yuán shàng dū. (Shàng) běijīng: Zhōngguó dà bǎikē quánshū chūbǎn shè, 2008. 4: 447.



A



0 20cm



Б

Зураг 3. Цахиурт овооны 5-р булинаас олдсон хоромсогын ясан чимэглэлийн хээ дүрс:

а. Ориуулгаас илэрч буй байдал; б. Сэргээж зурсан нь.



а. Ханзат 4-р були © Г.Батболд

б. Уушги 2-р були © Б.Очир

Зураг 4. Буга, согоо дүрсэлсэн байдал



Зураг 5. Доод цахир уул LII-р були: буга, таван нүдэн хээ зэргийг дүрсэлсэн байдал

© С.Хүрэлсүх